

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 11 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 10

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2024 оны 11 сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 94 шийдвэр: Засгийн газрын тогтоол-51, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-41, Засгийн газрын албан даалгавар-2 нийт 139 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 91.56 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 105 заалт нь нийт заалтын 79 хувийг
- Хэрэгжих шатанд 24 заалт нь 18 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 7 заалт 0.5 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 4 заалт 0.3 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайтад байршуулан ажиллаж хэвшил болоод байна. Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 11 сарын байдлаар хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.56 хувьтай байна. Мөн удаашралтай хэрэгжиж байгаа 6 заалтын хэрэгжилтийг авч үзвэл Урт хугацааны туршид хэрэгжих-3, Зохион байгуулалтаас шалтгаалсан-3 заалт байна. Удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр Төрийн захиргааны удирдлагын хэлтэст зөвлөмж хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг хяналтад бүрэн авах, тайлагнахад анхаарах зарим асуудлын талаар сар бүр зөвлөмжийг өгч ажилласнаар тодорхой үр дүн гарч байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн явц хамгийн бага буюу 70 хувийн үзүүлэлттэй байна. Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд "Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалт"-ын хэлтэст хамааралтай Аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах 1 заалтын бодит үр дүнг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хяналтад байгаа Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын холбогдох заалтуудаас бүрэн хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон нэг удаагийн шинжтэй 28 заалтыг түүвэрлэн хяналтаас хасуулах тэмдэглэгээг нэг бүрчлэн цахим системд орууллаа. /Хяналтаас хасуулах саналын дагуу unelgee.gov.mn цахим программаас хасаж өгнө үү/

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Бодлого хариуцсан хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд:

- 1.Хэрэгжилт нь тогтмолжсон болон тусгайлан он зааж хугацаандаа бүрэн хэрэгжээд дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан саналуудыг хяналтаас хасуулах саналаа ирүүлж хэвших.
- 2.Шинээр гарч буй хууль тогтоомж,тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.
3. Хэрэгжилтийг ирүүлэхдээ нотлох баримтат тулгуурлан тайлагнаж хэвших.

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС